



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 07 дугаар сарын 06 өдөр

Дугаар 64

Хэрлэн сум

LXIV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 64 дүгээр хуралдаан 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 14:00 цагт цахимаар 86,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 171 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2. Навдмын амралтын өдрүүд болохтой холбогдуулан амралтын газруудыг нээх эсэх, сүмд бие дааж шийдэж болох эсэх талаар хэлэлцэх,

Мэргэжлийн хяналтын газар

3. Коронавирус илрүүлэх түргэвчилсэн оношлуур худалдан авах санал танилцуулах,

Эрүүл мэндийн газар

4. Аймгийн хэмжээний хүн амыг дархлаажуулах ажлын явцын талаар мэдээлэл танилцуулах,

Эрүүл мэндийн газар

5. Коронавируст халдвар /Ковид-19/-аар жирэмсэн эмэгтэйчүүд өвдөж байгаатай холбогдуулан дэмжлэг үзүүлэх, урьдчилан сэргийлэх, хамтарч ажиллах талаар санал танилцуулах,

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар



6. Хот хоорондын нийтийн тээврийг 25-аас ихгүй хүнтэйгээр зорчуулах эсэх талаар хэлэлцэх,

Авто тээврийн төв

Эрүүл мэндийн газар

7. Халдварын улаан бүсэд томилогдож ажилласан албан хаагч нарыг ажлаас буухад "Сод" дэн буудалд тусгаарлах талаар санал танилцуулах,

Эрүүл мэндийн газар

/  / М.Бадамсүрэн
/  / Хур Т. Нармандах

8.Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлт танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Наг Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Үндэсний их баяр наадмын талаар авах зарим арга хэмжээний тухай" 183 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах, тогтоолтой танилцсан тухай албан бичгийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

1.2.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Үндэсний их баяр наадмын талаар авах зарим арга хэмжээний тухай" 183 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Хоёр Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Гаалийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од нарт:

2.1.Хилийн боомтуудад тавих хяналт шалгалт, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх ажлыг эрчимжүүлэх,

АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,

Зрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:


2.2.Аялал зугаалгыг зохицуулах журам боловсруулж аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

2.3.Зөвхөн гэр бүлийн хүрээнд аялал зугаалгыг зөвшөөрөх, зугаалж буй иргэд шинжилгээ хэрхэн өгөх тухай, халдвараас хамгаалах дэглэм мөрдүүлэх асуудал, сумдын бэлэн байдал, аж ахуйн нэгж байгууллагад бүс тогтоож бэлэн байдлыг хангуулах, зрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлэх, амралтын газруудын орчимд хяналтын цэг байгуулж хяналт тавьж ажиллуулах, иргэдээс хүсэлт хүлээн авах цахим хуудсанд аялал зугаалга шалтгааныг нэмж оруулах, талаар журамд тусгах,

2.4.Амралтын газруудтай хариуцлагын гэрээг байгуулах, гэрээний төслийг боловсруулж танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

 / М.Бадамсүрэн
/ Хур Г.Нармандах

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт;

2.5.Гэр бүлийн хүрээнд аялал зугаалгыг эхлүүлэхтэй холбогдуулан сумын Онцгой комисст мэргэжлийн байгууллагуудаас мэргэжил арга зүйгээр хангаж дэмжлэг үзүүлэн ажиллах,

Гурав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д,

3.1.Коронавирус илрүүлэх нэг удаагийн оношлуур 3000 ширхэгийг худалдан авахад шаардагдах 48,000,000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

3.2.Сумдын Эрүүл мэндийн төвийн нөөцөд байгаа нэг удаагийн түргэвчилсэн оношлуурыг татаж авах ажлыг зохион байгуулах,

Дөрөв.Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт,

4.1.Дархлаажуулалтад хамрагдаагүй тусгай заалттай, 0-12 насны хүүхдүүдээс бусад иргэдийг хамруулах ажлыг эрчимжүүлэх,

Тав.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Э.Жавхлан-д;

5.1.Коронавируст халдвар /Ковид-19/-аар жирэмсэн эмэгтэйчүүд өвдөж байгаатай холбогдуулан дэмжлэг үзүүлэх, урьдчилан сэргийлэх, хамтарч ажиллах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Э.Жавхлан,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Цагдаагийн хурандаа Т.Ганзориг,



Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт;

5.2.Жирэмсэн эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах ажлын хэсгийг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан ахлан Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төрөх тасгийн эрхлэгч, Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн тусламжийн хэлтсийн дарга, Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэндийн улсын хяналтын байцаагч, Цагдаагийн газар мэргэжилтэн, сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга, сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нарийн бүрэлдэхүүнтэй ажиллах,

/  / М.Бадамсүрэн
/  / Г.Нармандах

Зургаа.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр нарт:

6.1.Ачаа тээврийн ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг нэг автобусанд 30-аас ихгүй хүнтэйгээр зорчуулах, долоо хоног бүрийн Лхагва гарагт Чойбалсан–Улаанбаатар, Баасан гарагт Улаанбаатар-Чойбалсан чиглэлд тус тус 08:00 цагт зорчуулах, тарифын үнэ 34200 төгрөг байх, дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдснаас хойш 14 хоносон иргэнийг зорчуулах, иргэдийг гэр гэрт нь буулгах, Шуурхай штабын шийдвэрээр зөвшөөрсөн иргэдийг зорчуулах, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэхэд хяналт тавьж зохион байгуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

6.2.Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Долоо.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин нарт:

7.1.Халдварын улаан бүсэд томилогдож ажиллан бууж буй албан хаагч нарыг эхлэлэн "Сод" дэн буудалд 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийг дуустал хугацаанд тусгаарлахад шаардагдах 9.000.000 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

7.2.Тусгаарлах байраар дэн буудлуудыг түрээслэн ажиллаж байгаатай холбоотой санхүүгийн асуудлын талаар аж ахуйн нэгж болон мэргэжлийн байгууллагуудад чиглэл өгч, хяналт тавьж ажиллах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

7.3."Сод, Дулаан" дэн буудлуудын тусгаарлах байрны голомтын халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллах,

Найм.АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

8.1.Баасан гарагаас бусад өдөр 08:00-22:00 цагт согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн зөвшөөрөх тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

 / М.Бадамжүрэн
 / Г.Нармандах

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

8.2."ДБЭХС" ТӨХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн тус байгууллагын харьяа амралт, сувиллын газрын үйл ажиллагааг эхлүүлэх тухай хүсэлтийн дагуу хариуцлагын гэрээ байгуулах, камержуулалт хийх, газар дээр нь ажиллаж ажлын хэсгийн дүгнэлт гарган аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх.

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

8.3."Рэс" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу "Стэл голд" ХХК-ийн тусгаарлах байранд Онцгой байдал, Эрүүл мэндийн байгууллагын хяналттайгаар тусгаарлах тохиолдолд хяналтын цэгээр нэвтрүүлэхийг зөвшөөрөх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д.

8.4."Петрочайна Дачин Тамсаг" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу Дорнод аймагт нэвтрэх иргэдийн мэдээллийг тодорхой болгож аймгийн Онцгой комисст хүсэлт ирүүлэх талаар хариу мэдэгдэх,

8.5.Хэрлэн, Хөлөнбуйр сум, явуулын шинжилгээ, алслагдсан сумдын хяналтын цэгүүдийг 2021 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн дуустал ажиллахад шаардах халдвар хамгааллын хэрэгсэл нэг амны хаалт 21,483 ширхэг, N95 нэг удаагийн амны хаалт 620 ширхэг, нэг удаагийн халад 310 ширхэг, комбинзон 558 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгох,

8.6.Иргэдээс хүсэлт авах www.70584647.mn цахим хуудасны засан сайжруулалтад хийгдэх зардал 500,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас аймгийн Засаг даргын Тамгын газарт олгох,

8.7.Хөлөнбуйр сумаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Хяналтын цэгийн үйлчлэгчийн цалинд дэмжлэг хүсэх тухай" хүсэлтийн дагуу 1,260,000 төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

8.8.Хөлөнбуйр сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Хяналтын цэгийн цахилгааны төлбөрт дэмжлэг хүсэх тухай" албан бичгийн дагуу "ДБЭХС" ТӨХК-д коронавируст халдварын нөхцөл байдал нэмэгдэж байгаатай холбогдуулан аймгийн Онцгой комиссыг дэмжиж ажиллах тухай албан бичиг хүргүүлэх,

 /М.Бадамсүрэн
 /Хүр Г.Нармандах

Гваалийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од-д:

8.9.Аймгийн Онцгой комисст аж ахуй нэгж байгууллага, иргэдээс ирүүлсэн Баянхошуу хилийн боомтоор бараа материалаа татан авах хүсэлтийн дагуу Улсын Онцгой комисст албан бичиг уламжлах,

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа, Гваалийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од нарт:


8.10.БНХАУ-ын Өрнө дорнын соёл хөгжлийн харилцааны зөвлөл байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "190 ширхэг орны дэмжлэг үзүүлэх тухай" хүсэлтийн дагуу БНХАУ-аас татаж авахад шаардагдах зардал, бичиг баримт бүрдүүлэх ажлыг зохион байгуулах,


Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

8.11.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга, Статистикийн хэлтсийн мэргэжилтэн нарыг аймгийн Шуурхай штабын Тандалтын багт нэмэлтээр томилж ажиллуулах,

Аймгийн Эрүүл мэндийн албаны Тандалтын багийн ажлын хэсэгт:

8.12.Тандалтын багийг зохион байгуулалтаар хангаж ажиллах, тулгамдаж буй асуудлын талаар аймгийн Онцгой комисст, Шуурхай штабт танилцуулж ажиллахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ
ДАРГА ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ